



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюуны өмчийн тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын Их Хуралд өргөн баригдсан Патентийн тухай хууль, Зохиогчийн эрх түүнд хамаарах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах төслийн давхардал, зөрчлийг арилгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг

Нарийн бичгийн дарга:

- Эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
С.Цоггэрэл

Гишүүд:

- Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн дарга
С.Урангэрэл
- Хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ
- Мэргэжилтэн / шинжээч/ Б.Хэрлэнчимэг

2. Ажлын хэсгийн ажлыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг тооцож, 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч С.Ганзоригт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000443